



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, нийт 104,488,508.00 (нэг зуун дөрвөн сая дөрвөн зуун наян найман мянга таван зуун найман) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан хөрөнгийг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн
84/ дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ		Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөг
			нэг бүрийн үнэ	нийт үнэ		
			/Төгрөг/			
1	Каросо С-735 маркийн автобус 5513 ОРХ, арал ТМКЛ73520Gm16740	2008	104,488,508.00	104,488,508.00	104,488,508.00	0.00
	НИЙТ ДҮН		(нэг зуун дөрвөн сая дөрвөн зуун наян найман мянга таван зуун найм)			